

ТОРГОНЫ ЗАМД НОЁРХОХЫН ТӨЛӨӨХ ЖУЖАН УЛСЫН ТЭМЦЭЛ

П.ДЭЛГЭРЖАРГАЛ

МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор, доктор (Ph.D.)

Товч агуулга: Турфан, Таримын сав нутгийг *жужанчууд* эрхшээн ноёрхож байсан талаар хятад сурвалжид цэгцтэй мэдээ сэлт хомс байдгаас энэ талын судалгаа төдийлөн ахицгүй явсаар өнөөг хүрчээ. Харин 1997 онд Турфанаас олдсон элчийн бүртгэл тэмдэглэл нь Турфан, Таримын бүс нутагт *жужанчуудын* явуулсан бодлого, үйл ажиллагааг тодруулахад чухал ач холбогдолтой бөгөөд *жужанчууд* Турфанд төвтэй Гаочан ванлигаар дамжуулан Таримын сав, умард Энэтхэгийн улс орнуудтай өргөн дэлгэр харилцаж байсныг нотолж байна. Гаочанаас Бархөлөөр дайран Тэнгэр уулын зүүн хэсэг Богд уулыг даван Жужан улс руу аялан явдаг зам нь элчин харилцаа төдийгүй Торгоны замын умард салааны нэгэн чухал зам байжээ. Хятад сурвалжид “Хуйхуй зам” хэмээн тэмдэглэгдсэний улмаас Уйгурын зам хэмээн нэрлэсэн энэ зам угтаа Жужаны үеийн зам ажгуу. Жужан улс нь Турфан, Таримын бүс нутагт эрхшээл нөлөөгөө тогтоон, торгоны замын гол зангилаа хэсгийг хянаж байсан төдийгүй Тоба Вэй, Түгүхүн (Тогоон), Эфталит улсуудтай нийт торгоны замыг хянахын төлөө өрсөлдөн тэмцэлдэж байсан билээ.

Түлхүүр үг: Жужан, Турфан, Таримын сав нутаг, торгоны зам, элч

Турфан, Тамирын сав нутаг нь эртнээс өрнө дорно, умард өмнөдийг холбосон олон улсын худалдааны замын нэг гол зангилаа нутаг байсан. Тиймээс Таримын сав, Турфаны бүс нутаг нь Монгол нутаг дахь нүүдэлчдийн эзэнт гүрнүүдийн хувьд эдийн засаг, соёлын солилцоо, олон улсын харилцаа, геополитикийн хувьд чухал ач холбогдолтой бүс нутаг байсаар ирсэн билээ. Энэ бүс нутгийг хятад сурвалжид баруун бүс нутаг буюу баруун орон (西域xiyu) хэмээн нэрлэдэг. Хожим өрнөдийнхөн д Дорнод Туркестан, Манж Чин гүрэн шинэ хязгаар буюу Шинжаан хэмээн нэрлэх болсон.

Турфан, Таримын сав газрыг хятадын нутагтай холбодог Ганьсугийн коридор, Хэси нутагт эртнээс юэжи нар нутаглаж байсан бөгөөд тэд баруун бүс нутгийн орнуудад ч голлох нөлөөтэй байсан хэмээн үздэг. Хүннү гүрэн хүчирхэгжин мандмагц энэ бүс нутагт ноёрхлоо тогтоох бодлогыг тууштай явуулжээ. Юэжийн эсрэг хийсэн гурван удаагийн аян дайнд НТӨ 207/206, 177, 167 оны орчим хүннүчүүд ялалт байгуулснаар юэжи нарыг баруун тийш шахаж, Ганьсугийн

коридор хүннүгийн мэдэлд шилжсэн төдийгүй баруун бүс нутгийг Хүннү гүрэн хянах болсон билээ¹. Хань улс Уди хааны үе (НТӨ 40-87)-д Хүннүтэй хийсэн олон жилийн хүнд хүчир дайны явцад Хэси, Ганьсугийн коридор нутгийг Хүннүгээс булаан авснаар баруун бүс нутгийн орнуудтай шууд харилцах боломжтой болж, энэ бүс нутагт Хан улсын нөлөө буй болж эхэлсэн. Хүннү гүрэн өмнөд, умард хэмээн хуваагдан хүчин чадал нь суларсныг ашиглан Хань улс баруун бүс нутагт нөлөөгөө тогтоохыг төлөө Хүннүтэй тэмцэлдэх болов. Хүннүг залган мандсан Сяньби гүрэн хүчирхэгжин газар нутгаа тэлж байхад, Хань улс бууран доройтсоор Зүүн Хань улс 220 онд мөхөв. Сяньби гүрэн хуучин Хүннүгийн эзэмшиж байсан бүхий л газар нутагт хяналтаа тогтоосон ч энэ хүчирхэг байдал нь удаан үргэлжилсэнгүй. 235 оны үед Сяньби гүрэн задарснаар сяньби угсааны олон жижиг улсууд болон бутарчээ.

Хятадад Гурван улсын үеийн үймээн самуун, задрал үргэлжилж, энэ байдлыг ашиглан хүннү болон сяньби угсааны улсууд умард хятадад өөрсдийн улсыг байгуулан ноёрхлоо тогтоов. Умард хятадад дангаар ноёрхлоо тогтоохын төлөөх олон жил үргэлжилсэн тэмцэлд тоба сяньбичууд ялалт байгуулан, Тоба Вэй улсыг байгуулж байхад, Турфан, Таримын сав нутагт жужанчууд ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянах болжээ. 439 онд Тоба Вэй улс умард хятадын нэгтгэн, Дуньхуаны бүс нутгийг хяналтдаа авснаар Таримын савд нөлөөгөө тогтоох бодлого явуулах болж Жужан улстай өрсөлдөн тэмцэлдэх болов.

Жужан улс нь Турфан, Таримын бүс нутагт ноёрхож, торгоны замын гол зангилаа нутгийг хянаж байсан талаар түүх бичлэгт тусгагдаагүй явсаар эдүгээ хүрчээ. Энэ бүс нутагт Жужан улсын явуулсан бодлого, үйл ажиллагаатай холбоотой үйвэр түүвэр мэдээ сэлт хятадын албан түүх сурвалжуудад байдаг. Гэвч хятад сурвалжийн мэдээ хомс, цэгцтэй тэмдэглэгдээгүй нь үйл явдлыг тодруулахад бэрхшээл учруулдаг. Харин сүүлийн үед Турфанд явуулсан археологийн малтлагаар тухайн үеийн «элчийн бүртгэл тэмдэглэл» олдсон нь Жужан ба Турфан, Тамирын бүс нутгийн орнуудын хоорондын элчин харилцааг тодруулах анхдагч сурвалж гэдэг утгаараа чухал ач холбогдолтой билээ.

Энэхүү элчийн бүртгэл тэмдэглэл нь жужанчууд Турфан дахь Гаочан улсаар дамжуулан Таримын сав нутгийн болон умард Энэтхэгийн улс орнуудтай өргөн дэлгэр харилцаж байсныг нотолж байна. Элчийн бүртгэл тэмдэглэлийг хятад болон бусад сурвалжийн мэдээ зангитай харьцуулан судалж, Турфан, Таримын сав нутагт Жужан улсын явуулсан бодлого, үйл ажиллагааг илүү тодруулах боломжтой юм. Түүнчлэн Гаочанаас Бархөлөөр дайран говь туулж Жужан улс руу аялан явдаг зам нь элчин харилцаа төдийгүй Торгоны замын умард салааны нэгэн чухал зам байжээ. Хятад сурвалжид “Хуйхуй зам” хэмээн тэмдэглэгдсэн ч бид тус замыг Жужаны үед байсан хэмээн үзэж байна. Жужан улс нь баруун бүс нутгийн орнууд болон Дундад Азид хүч нөлөө ихтэй байж, торгоны замын гол зангилаа хэсгийг хянаж байсан нь Евразийн түүхэнд хүчирхэг нөлөөтэй байсны нотолгоо юм.

¹ Дэлгэржаргал П. Хүннү ба Юэжи, Усунь-ий харилцаа. *Studia Historica*. Tomus XLIII-XLIV. Fasc.3, УБ., 2015. т. 46-57 үзнэ үү.

1. Жужан улсын тэлэлт: Турфан, Таримын сав нутагт ноёрхлоо тогтоосон нь (402-439 он)

Жужаны хаант улс нь Солонгосоос Тэнгэр уул, Таримын сав газарт ноёрхлоо тогтоосон хүчирхэг улс байв. Баруун бүс нутаг дахь нөлөөгөө ашиглан Евразийн олон улсын худалдаан замыг хяналтдаа байлгах нь Жужан улсад стратегийн чухал ач холбогдолтой байсан ажээ. Жужан улс Шэлүн хааны үед ихээхэн хүчирхэгжин, газар нутгаа үлэмж тэлсэн билээ. “Вэй улсын судар”-ын Жужаны шастирт:

“[Шэлүний үед Жужан нь] хүчирхэг бөгөөд цэцэглэн хөгжсөн улс байв. Өвс усны сайныг даган нэг газраас нөгөөд нүүдэллэнэ. Тэдний газар нутаг баруун тийш Яньци (焉耆 *yanqi*)-аас зүүн зүг Солонгос (朝鮮 *Chaoxian*) хүрнэ. Умард зүг Ханьхай (瀚海 *Hanhai*), өмнө зүг Даци (大磧 *Daqi*)-д тулна. Тэдний хуралдай Дуньхуан (敦煌 *Dunhuang*), Жан-е (張掖 *Zhanye*)-ын хойно болдог. Жужаны довтолгоонд өртсөн жижиг ванлигууд тэднийг дагахаас өөр сонголт байхгүй”² гэжээ.

Сурвалжийн дээрх мэдээнээс Шэлүний үед Жужан улс Баруун бүс нутгийн Яньци буюу Карашар хүртэлх нутагт ноёрхлоо тогтоосон нь мэдэгдэж байна. Тиймээс V зууны эхэн үе гэхэд *жужанчууд* Турфаны бүс нутаг төдийгүй умард Таримын сав нутгийг хүртэл ноёрхолдоо оруулсан гэж үзэж болох юм.

Татар хаан (414-429)-ы үед *жужанчууд* Таримын сав газарт цэрэг, дипломатын идэвхитэй үйл ажиллагаа явуулж Яньцигаас гадна, Шаньшань (鄯善 *Shanshan*), Чюци (龟兹 *Quici*), Гумо (故墨 *Gumo*) зэрэг зүүн Таримын савын улсуудад ноёрхлоо тогтоон³ газар нутгаа өргөтгөжээ. Тай-яны 1 дүгээр онд (435 он) Умард Вэй улсаас Гаочанд илгээсэн элч Ван Эншэн (王恩生 *Wang ensheng*)-ийг *жужанчууд* барьцаанд авсанаас үзэхэд Жужан улс энэ бүс нутагт ноёрхлоо бүрэн тогтоосон байсан нь тодорхой юм.

Ийнхүү Шэлүний үеэс (402-414 он) эхлэн *жужанчууд* хүчирхэгжин газар нутгаа тэлж эхэлсэн бөгөөд 402-439 оны хооронд Жужан улс баруун тийш үлэмж их газар нутгийг байлдан эзэлж, өөрийн нөлөөнд оруулсан. Гэвч байлдан дагууллын явцад *жужанчууд* баруун тийш хаана хүртэл довтолсон нь төдийлөн тодорхойгүй бөгөөд сурвалж бичигт тодорхой тэмдэглэгдэн үлдсэнгүй. Харин “Лян улсын судар”-ын 54 дүгээр бүлэгт:

“Юань Вэй (*yuanwei* 元魏) нар Сангань (*Sanggan* 桑乾)-д суурьшиж байхад Хуа (*Hua* 滑) [Эфталит] нь жижиг улс байсан бөгөөд Жужан (*ruirui* 芮芮)-ы харьяат байв”⁴

гэсэн ихээхэн сонирхолтой мэдээ тэмдэглэгдсэн байдаг. “Санганьд суурьшиж байхад” гэдэг нь *тобачууд* анх Пинчэн (*Pingcheng* 平城) хотоор нийсэллэж байсан 398-494 оны үеийг хэлж байгаа хэрэг юм. *Эфталитууд* хэзээ, хаана суурьшиж байхдаа Жужан улсын хараат байсан бэ гэдэг асуулт гарч ирнэ. Жужан улсын баруун тийш газар нутгаа тэлэх бодлого, үйл ажиллагаанд саад болох томоохон хүч Зүүн гар, Турфаны хотгор, Тамирын сав нутагт байсангүй. Турфаны сав нутаг дахь баян бүрдийн жижиг орнуудад Жужаны цэргийн хүчийг сөрөх боломж байгаагүй тул бүгд дагаар орохоо илэрхийлсэн бөгөөд томоохон эсэргүүцэл тулаан болоогүй бололтой. Тиймээс *жужанчууд* баруун өмнө зүг аян дайнаа

² 魏書 (*Wei shu*), 卷103, 蠕蠕傳。中華書局出版, 第二版, 1984. 第 2290-2291 頁;

³ 宋書 (*Song shu*). 卷 95, 索虜傳。中華書局出版, 1974. 第2357頁;

⁴ 梁書 (*liang shu*), 卷54, 西北諸戎。中華書局出版, 第二版, 1984. 第 812 頁;

үргэлжлүүлсээр Тохарстаны нутаг хүрч, Эфталитыг байлдан дагуулсан хэмээн таамаглаж болохоор байна. Өмнөд хятадын улсууд болон Тоба Вэй улс тухайн үед Тохарстан, Гандхарын нөхцөл байдлын талаар мэдээлэлгүй байсан тул сурвалж бичигтээ тэмдэглэл үлдээсэнгүй. Харин хожим *эфталитуудтай* харилцах үедээ өмнө нь Жужаны хараат байсан гэдгийг олж мэдээд тэмдэглэн үлдээсэн хэрэг хэмээн үзэж болох юм. “Лян улсын судар”-ын дээрх мэдээнээс үзвэл, жужанчуудын баруун тийш газар нутгаа тэлэх аян дайн Тохарстан, Гандхар хүрсэн хэмээн үзэж болохоор байна. Жужанчуудын Тохарстан дахь ноёрхол удаан үргэлжилсэнгүй, *эфталитууд* хүчирхэгжин Жужаны эрхшээлээс гарч, газар нутгаа тэлэх болжээ.

Жужан улс торгоны замын дагуу газар нутгаа тэлж байхад Вэй улс нь умард хятадыг нэгтгэх тэмцэлд гол анхаарлаа хандуулж байсан бөгөөд Ганьсугийн бүс нутаг ч тэдний хяналтад байсангүй. Ганьсугийн бүс нутагт нэгэн үе сяньби угсааны Баруун Цинь улс хүч нөлөөтэй байв. Гэвч Хүннү угсааны Умард Лян улс нь Баруун Лян улсыг 420 онд өөрийн эрхшээлд оруулснаар Ганьсугийн бүс нутагт дангаар ноёрхох байр суурьтай болсон. Энэ үеэс Умард Лян улс нь Турфан, Таримын бүс нутагт нөлөөгөө бэхжүүлэх бодлогыг явуулах болов. Гэвч 439 онд Тоба Вэй улсад эзлэгдсэнээр Умард Лян улс мөхжээ. Тоба Вэй улсад бутцохигдсон Умард Лянгийн үлдэгдэл хүчин Дуньхуанаас Таримын сав нутаг руу зугтжээ. Умард Лян улсыг захирч байсан хүннү угсааны язгууртан Жүцү Ухүй, Жүцү Анжоу нар баруун бүс нутагт хүрч, Жужантай холбоотон болж, тэдний дэмжлэгтэйгээр Шаньшань улсыг эзлэн суусан байна.

Харин Тоба Вэй улс нь Умард Ляныг эзлэн авснаар Дуньхуан, Ганьсугийн бүс нутагт бүрэн ноёрхох болов. Дуньхуан, Ганьсугийн бүс нутагт ноёрхлоо тогтоосноор Умард Вэй улс Баруун бүс нутагтай шууд хиллэх болж, энэ бүс нутгийн орнуудтай харилцаагаа бэхжүүлж, нөлөөгөө дэлгэрүүлэх бодлого явуулах боломжтой болсон байна. Умард хятадыг бүрэн хяналтдаа оруулснаар Тоба Вэй улс хүчирхэгжин, улмаар Баруун бүс нутгийн орнуудын хэрэгт оролцон, бүс нутаг дахь Жужаны нөлөөг сулруулахыг оролдох болжээ. Тоба Вэй улс нь Таримын савын Карашар, Куча хүртэл нөлөөгөө тэлэх бодлого явуулах болов. Ийнхүү Тоба Вэй болон Жужан улсын хооронд Таримын бүс нутагт ноёрхлоо тогтоон торгоны замыг хянахын төлөө тэмцэл өрнөж эхэлжээ.

2. Торгоны замын төлөө Жужан, Тоба Вэйн тэмцэл (439-460 он)

“Вэй улсын судар”-ын “Баруун орны шастир”-т өгүүлснээр Тоба Вэй улсын Шизү (世祖shizu) хаан Баруун бүс нутаг дахь Жужаны ноёрхлыг бууруулах, өөрийн нөлөөг дэлгэрүүлэх бодлогыг явуулж, Баруун орнуудтай идэвхитэй харилцаж эхэлсэн байдаг. Харин Жужан улс Тайяны 4 дүгээр он (438)-д Баруун бүсийн орнууд руу элч илгээн, “Вэй улс одоо хүч сул, харин манай улсын хүч агуу” хэмээн мэдэгдээд Вэй улсаас дахин элч хүлээн авч болохгүй⁵ гэдгийг анхааруулсан байдаг. Жужаны хүч нөлөөнөөс айсан Баруун бүсийн улсууд Умард Вэй улстай харилцахаас эмээх болжээ. Эндээс Жужан улс нь Тарим бүс нутагт бүрэн ноёрхлоо тогтоосон байсан нь харагдах төдийгүй энэ бүс нутагт Умард Вэй улсын нөлөө дэлгэрэхээс сэргийлж байсан нь тодорхой байна.

⁵ 魏書 (Wei shu), 卷102, 西域傳。中華書局出版, 第二版, 1984. 第 2260 頁;

Улмаар Тоба Вэй улс бүс нутгийн хэрэгт цэргийн хүчээр оролцох болсноор эмх замбараагүй дайн байлдаан үүсчээ.

Энэ талаар “Вэй улсын судар”-ын Тан Хэ-(唐和 tanhe)-ийн намтарт: “Жужаны цэргийн командлагч Ару (阿若Aruo) цэргээ удирдан [Тан] Хэ-ийн цэргийг тосон байлдсан. [Аругийн цэрэг] Байли хот (白力城 Bailicheng)-д ирэхэд Тан Хэ-ийн тушаалаар таван зуун морьт цэрэг Гаочан руу довтлов. Байлдаанд [Тан] Чи (契Qi) болон Ару хоюул алагдсан. [Тан] Хэ үлдсэн хүчээ удирдан Цяньбү (前部王國Qianbu Wangguo) вант улс руу хөдлөв. Энэ үед, Зүци Аньжоу (沮渠安周Juqi Anzhou) нь Хэнже хот (橫截城Hengjiecheng)-д сууж байв. [Тан] Хэ тэднийг довтолж, [Жүци] Аньжоу (安周 anzhou)-ийн үеэл [Жүци] Шү (樹 shu)-г алсан. Бас Гаонин (高寧Gaoning), Байли (白力Baili) хоёр хотыг эзэлж, тэндэхийн захирагчдыг цаазалсан”⁶ хэмээжээ.

Сурвалжид дурдсан дээрх үйл явдал 442 онд болсон бөгөөд Тан Хэ цэргээ удирдан Гаочан руу ирэхэд түүний ван Кан Шуан (闕爽kanshuang) Шаньшань улсын захирагч Жүцү Ухуйгаас тусламж хүссэн. Умард Лянгийн үлдэгдэл хүчин есөн сард Гаочаныг эзлэн авахад Кан Шуан ван Жужан руу зугтжээ. Үйл явдал хурдацтай өрнөн нөхцөл байдал Жужан улсад таагүйгээр өөрчлөгдөн, Тоба Вэй улсын нөлөө Таримын сав газар дэлгэрч эхэлсэн байна. Умард Лянгийн үлдэгдэл хүчин Жужан ба Тоба Вэй гэсэн хоёр талын дунд тоглолт хийн, дундаас нь хожоо олох бодлого баримтлах болсноос нөхцөл байдал туйлын ээдрээтэй болж байв. Гэсэн хэдий ч Таримын сав нутгийн Яньци, Чюци болон баян бүрдийн бусад жижиг улсууд Жужаны талыг баримтлан дэмжсээр байсан. Жужанчууд Умард Лянгийн үлдэгдэл хүчтэй холбоо байгуулж, тэдний дэмжих замаар Таримын сав нутаг дахь нөлөөгөө бэхжүүлэх бодлого явуулж зохих амжилтад хүрсэн байна. Тайпин жэнзүнгийн 11 дүгээр он буюу 450 онд Чэши-ийн вангаас Тоба Вэй улсад илгээсэн захидалдаа:

“Найман жилийн өмнөөс манай улс Ухуй (Wuhui)-ийн довтолгоонд нэрвэгдэх болсон. Манай хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэж, өөрсдийн амь насыг хамгаалах боломжгүй болсон. <...>. Би хүчин мөхөсдөж, зугтахгаас өөр сонголтгүй болж зүүн тийш зугтсан ч манай цэргүүдийн гуравны нэг нь амьд үлдэв. Тэд удахгүй Яньцигийн зүүн хил дээр ирэх болно” хэмээгээд Тоба Вэй улсад дагаар орохоо илэрхийлж, тусламж хүссэн байдаг⁷.

Захидлаас үзэхэд, Чэши улсын нийслэл Зяохэ (Jiaohu, Яр хот) хот Жужан болон тэдний холбоотон Умард Лянгийн хүчинд эзлэгдэн, Чэшийн ван цэргүүдээ дагуулан Яньцийн зүг зүтсэн ч цэргүүдийнх гуравны нэг нь амь гарсан нь тодорхой байна.

Жужан улс Таримын сав нутагт ноёрхлоо бэхжүүлэхэд Умард Лянгийн үлдэгдэл хүчийг ашиглаж, тэд эзэн ба хараат түшмэг улсын харилцаатай байв. Умард Лянгийн үлдэгдэл хүчин Жужаны дэмжлэгээр Таримын сав нутагт хүчирхэгжих тусам бие даахыг санаархах болсноор тэдний хооронд зөрчил тэмцэл гарах болсон бололтой. Нөгөө талаар Умард Лянгийн үлдэгдэл хүчин нь Жужан улсын цаашдын тэлэлтэд саад учруулах болсон ажээ.

⁶ 魏書 (Wei shu), 卷 92, 唐和傳. 中華書局出版, 第二版, 1984. 第 962頁;

⁷ 魏書 (Wei shu), 卷102, 西域傳. 中華書局出版, 第二版, 1984. 第 2264-2265 頁;

Жужан улс Таримын сав нутагт цэрэг зэвсгийн хүчээ хуралдуулан, улмаар 460 онд Умард Лянгийн үлдэгдэл хүчийг довтлон устгаж, Анжоу (An-chou)-г алж, Кан Бошоуг Гаочаны ван болгосон. Ийнхүү Гаочан нь Жужан улсын бүрэн хараат ванлиг болсон бөгөөд *жужанчуудын* Таримын сав нутгийг хянах, бүс нутгийн орнуудтай харилцах гол түшиц болж байсан ажээ.

3. Торгоны зам дахь жужанчуудын ноёрхол (460-492 он)

“Умардын түүх”-энд тэмдэглэснээр, Хэпингийн тэргүүн он буюу 460 онд жужанчууд Гаочаныг эзэлж, Кан Божоуг Гаочаны ванд суулгасан хэмээжээ. Сурвалжийн дээрх мэдээнээс үзэхэд, 460 оноос Гаочаныг захирах болсон Кангийн гэр бүл нь Жужаны дэмжлэгээр ван болж, тэдний өмнө үүрэг хүлээх болжээ. Умард Лянгийн язгууртнуудыг дагалдан Гаочанд ирж суурьшин Ашина овогтой болсон “төмөрчид”-ийг жужанчууд Алтайн уул руу нүүлгэн шилжүүлж төмрийн алба авах болсон байна.

Жужанчууд 471 онд өрнө дорнын худалдааны замд хяналтаа тогтооход стратегийн чухал байрлал бүхий Хотан улсыг эзлэн авав. Хотаны ван Тоба Вэй улсаас тусламж хүссэн ч тобачууд газар нутаг хол гэдэг шалтаг хэлж туслахаас татгалзжээ. Кан Божоу вангийн үед Гаочан нь Жужаны бүрэн ноёрхолд байж, Турфан, Таримын сав нутгийн орнуудтай харилцахад чухал үүрэг гүйцэтгэж байв. Кан Божоу 477 онд нас барахад түүний хүү Кан Ичэн (Kan Yicheng) залгамжилжээ. Турфан, Таримын сав нутагт явуулсан идэвхитэй бодлогын үр дүнд Жужан улс нь бүс нутагт дангаар ноёрхох болсноор бүс нутагт амар амгалан болж, тогтвортой байдал тогтжээ. Ийнхүү Таримын сав нутгийг ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянахын төлөөх тэмцэлд жужанчууд ялалт байгуулсан хэмээн үзэж болно.

460 оноос 490 хэдэн он хүртэл 30 гаруй жил Баруун бүс нутагт Жужан улс бүрэн ноёрхож, бүс нутагт амар амгалан тогтож, худалдаа, гар урлал цэцэглэн хөгжсөн хэмээн үзэж үзэж болно. Энэ үеийн Жужан улс болон Таримын бүс нутгийн орнуудын харилцааны түүхэнд холбогдох бичгийн шинэ дурсгал олдсон нь судалгааны чухал ач холбогдолтой юм. 474-475 онд холбогдох элчийн бүртгэл, 482 онд холбогдох элч нарт тарааж өгсөн эд зүйлийн бүртгэл Турфанаас олдсон нь Жужан болон Гаочан улсын харилцаа төдийгүй жужанчууд ба Таримын сав нутгийн орнууд, Дундад Ази, өмнөд Хятад, Энэтхэгийн улсуудтай өргөн дэлгэр харилцаатай байсныг нотолж байгаа анхдагч эх сурвалж болохын хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Энэ сурвалж нь жужанчууд баруун бүсийн орнууд, торгоны замд хяналтаа тогтоон ноёрхож байсныг давхар баталж байна.

Элчийн бүртгэл тэмдэглэл

1997 онд Турфаны Янхайн оршуулгаас V зууны сүүлийн хагаст холбогдох Жужан ба баруун орны элч төлөөлөгчдийн талаарх мэдээлэл агуулсан хоёр хэсэг бичгийн чухал дурсгал олджээ. Хоёр хэсэг энэхүү бичгийн дурсгал нь Турфан дахь Гаочан улсаар дайран өнгөрөх Жужаны болон баруун орны элч нарын бүртгэл юм. 1 дүгээр булшнаас олдсон боол худалдан авах гэрээнд “юнкан (永康 yongkang)-ы 12 дугаар он” (477 он) хэмээн тэмдэглэсэнд үндэслэн он цагийг тогтоосон бөгөөд бусад тэмдэглэлүүдэд “... дүгээр он” гэж бичсэн боловч ямар хааны он гэдгийг

тэмдэглээгүй ажээ. Турфанаас олдсон нэг бүлэг элчийн бүртгэл нь юнканы 9-10 дугаар он буюу 474-475 оны Гаочанд ирсэн элч, элчийг дагалдах хүн болон агтын бүртгэл ажээ⁸. Энэхүү элчийн бүртгэлийн баримтад:⁹

1. “9 дүгээр оны 10 сарын 8-ны өдөр, Чулуоган Үгэн (處羅幹无根Chuluogan Wugen)-ийг дагалдах, Гаонин (高寧Gaoning)-аас 90 хүн, Мохэянь (摩訶演 Moheyan)-аас 10 хүн, [хүн бүрд] нэг морь гаргав”.
2. “9 дүгээр оны 10 сарын 20-ны өдөр, Жэн Ама (鄭阿卯Zheng Amao)-ыг дагалдах, 85 хүн Гаонинаас (高寧Gaoning), 36 хүн Байжи (白芳Baiji)-аас, 26 хүн Ваньдү (万度Wandu)-аас, 15 хүн Циян (其養Qiyang)-аас, [хүн бүрд] нэг морь гаргав”.
3. “9 дүгээр оны 12 сарын 2-ны өдөр, Учан [Удян] (烏菟Wuchang, Udyana)-ы элчийг Яньци [Карашар] (焉耆Yanqi) руу дагалдах, 118 хүн, [хүн бүрд] нэг морь, Гаонин-аас 85 хүн, Вандү-ээс 26 хүн, Цяньян (乾養Qianyang)-аас 7 хүн”.
4. “10 дугаар оны ... сарын 5-ны өдөр, Янци-ийн ванг умард уул руу дагалдах, Гаонин-аас 84 хүн, Хэнже (橫截Hengjie)-ээс 46 хүн, Байжи-ээс 36 хүн, Ваньдү-ээс 26 хүн, Циян-аас 15 хүн, Вэйшэнь (威神Beishen)-ээс 2 хүн, Люпо (柳婆Liupo)-аас 47 хүн, нийт 256 хүн, [хүн бүрд] нэг морь гаргав”.
5. “10 дугаар оны 3 сарын 14-ний өдөр, Полуомэн [Брахман] (婆羅門Poluomen, Brahman)-ий элчийг Яньци руу дагалдах, Гаонин-аас 84 хүн, Хэнже-ээс 46 хүн, Байжи-аас 36 хүн, Тянди (田地Tiandi)-ээс 16 хүн, нийт 182 хүн, [хүн бүрд] нэг морь”.
6. “10 дугаар оны 3 сарын 8-ны өдөр, У (吳Wu)-ын зочин Зихэ (子合zihé) элчийг умард уул руу дагалдах, Гаонин-аас 83 хүн, Байжи-аас 25 хүн, нийт 108 хүн, [хүн бүрд] нэг морь гаргав”.
7. “9 дүгээр оны 7 сарын 23-ны өдөр, Руозю (若久Ruojiu)-г Яньци руу дагалдах, Гаонин-аас 68 хүн, [Хэн]же ([Heng] jie)-ээс 40 хүн, Байжи (Baiji)-аас 32 хүн, Вэйшэнь (Beishen)-ээс ... хүн, Ваньдү-ээс 23 хүн, Цяньян-аас 14 хүн, Люпо (Liupo)-аас 30 хүн, Аху (Ahu)-аас 12 хүн, Мохэянаас (Moheyan)-аас 16 хүн, Зуожин (Zuojin)-ээс 18 хүн, Гаочан (Gaochang)-аас 7 хүн”.
8. “9 дүгээр оны 6 сарын 12-ны өдөр, Полуоган (婆羅幹Poluogan)-ыг умард уул руу даган хамгаалах, Гаонин (Gaoning)-аас 68 хүн, Вэйшэнь (Beishen)-ээс 5 хүн, Ваньдү (Wandu)-ээс 23 хүн, Циян (Qiyang)-аас 12 хүн, Люпо-аас 30 хүн, Аху (阿虎Ahu)-аас 15 хүн, Мохэянь-аас 13 хүн, Зуожин (喙進Zuojin, huijin)-ээс 10 хүн, Хэнже-ээс 40 хүн, [хүн бүрд] нэг морь гаргав” хэмээн тэмдэглэжээ.

Эдгээр бүртгэлээс үзвэл, элчийн бүртгэлийг хөтлөх тогтсон дараалал, дэг байжээ. Эхлээд он сар өдөр, хамгаалах элчийн нэр, очих газар, хүний тоо, хүний тоогоор морь гаргасан талаарх тэмдэглэл гэсэн дарааллаар бичигддэг байжээ. Элч нарын нэрсээс Полуоган (婆羅幹Poluogan SK bwā.lā.kān < *buluγan (Булган) байх), Руозю (若久Ruojiu SK íak.ków < *naγai~noγoi, Жужаны Нагай хаан, Алтан ордны түмтийн ноёны Ногай гэх нэртэй ижил юм), Чулоган Үгэн (處羅幹Chuluogan 无根 Wugen *chulugun ebügen “чулуун өвгөн/эбүгэн” гэж болох нь тэгвэл Чуловүгэн эс-

⁸ 陳昊。吐魯番洋海1號墓出土文書年代考釋。敦煌吐魯番研究， №10。上海 2007。第11-20頁。

⁹ 榮新江。吐魯番新出送使文書與闐氏高昌王國的郡縣城鎮。敦煌吐魯番研究， №10。上海 2007。第22頁。

вэл Чуломогэн гэж бичвэл бараг Чулуун эбүгэнээ илэрхийлчих мэт), Жэн Ама (鄭阿卯 Zheng Amao *degei böö гэх үг байж мэдэх нь) хэмээх нэрийг алтай язгуурын үг хэмээн баттай үзэж болох төдийгүй жужан буюу монгол үг байх магадлал өндөр юм.

Эдгээр элчийн нэрийн ард элч гэсэн үг тэмдэглээгүй байгааг судлаачид Гаочанд олонтаа ирсэн тэдний танил Жужан элч нар байх магадлалтай хэмээн үзжээ¹⁰. Бусад нэрийн ард элч (使 shi) болон зочин (客 ke) гэсэн үгийг хамт бичсэн байна.

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, юнканы 9 дүгээр оны (474 он) 6 сарын 12-нд Жужаны элч Полуоган Үгэн нь Гаочанаас умард уулыг дайран Жужан руу буцжээ. 7 сарын 23-нд Жужаны элч Роужю Гаочанаар дайран Яньци (Карашар) руу явсан. Мөн оны 10 сарын 8-нд Жужаны элч Чулоган Үгэн, 12 хоногийн дараа 20-нд элч Жэн Ама Гаочанаас Жужан руу тус тус буцсан ажээ. 474 оны 12 сарын 2-нд Энэтхэгийн Удяна (Udyana)-ын элч Жужанаас буцахдаа Гаочаныг дайрсан. 475 оны 3 сарын 8-нд Өмнөд хятадын болон зүүн өмнөд Тарим нутгийн элч нар Гаочаныг дайран умард уулаар дамжин Жужан руу явсан байна. Мөн сарын 14-нд Энэтхэгийн Брахман улсын элч Карашар руу явав. ... сарын 5-нд Карашарын ван Гаочанаар дайран Жужан руу аялжээ. Элчийн бүртгэл нь Жужан улс нь Турфан, Таримын сав нутгийн орнууд болон умард Энэтхэгийн Удяна, Брахман улстай идэвхитэй харилцаж байсныг нотлон харуулж байна. Умард Энэтхэгийн улсууд Таклимаканы цөлийг туулан баян бүрдийн жижиг улсуудыг дайран Таримын савын Хотан, Кархаликаар [Каргалик] дайран, Турфан дахь Гаочаны ванлигаар дамжин Жужан руу аялан явдаг байсан ажээ. Өмнөд хятадын улсууд ч Умард Вэй улсын нутгаар дайрахаас болгоомжлон Түгүхүний нутаг болон Тарим, Турфаны ванлигуудаар дамжин Жужантай харилцдаг байв.

Гаочаны ван нь Жужан улсын элчийг хүрэх газарт нь хамгаалан саадгүй хүргэх, унаа агт, хоол хүнс, орон байраар хангах үүрэг хүлээдэг байсан байна. Элчийн бүртгэлийн явах чиглэлд “умард уул” хэмээн тэмдэглэсэн нь Жужан руу явах замыг буюу Тэнгэр уулын салбар болох Богд уулыг хэлж байгаа нь тодорхой юм. Элчийн бүртгэл тэмдэглэлээс үзвэл, Гаочаны ванлиг нь Турфан, Таримын сав нутагт Жужан улс хяналтаа тогтоох гол түшиц болж байсан төдийгүй Жужан улс Таримын сав, умард Энэтхэгтэй харилцахад чухал үүрэгтэй байсан ажээ.

Ийнхүү Гаочан улс нь Таримын бүс нутаг, Энэтхэгээс Жужан руу явах гол зам, зангилаа газар болж байв. Яньци улс руу явах элч Гаочанаар дайран явж байгаа талаар элчийн бүртгэлд “10 дугаар оны ... сарын 5-ны өдөр, умард уул руу явах Яньци-ийн ванг даган хамгаалах” хэмээн тэмдэглэжээ. Яньци нь одоогийн Карашарт оршин байсан томоохон ванлиг бөгөөд торгоны замын умард салаа нь Гаочанаас Яньцигаар дайран Куча орно. Яньци нь торгоны замын чухал зангилаа газар болж байв. 466-468 оны үед Жужаны цэрэг Хотан хүрч байсан болохоор Яньци аль хэдийн Жужаны нөлөөнд орсон байсан нь мэдээж юм. Тиймээс 475 онд Яньцийн ван Жужан руу очиж байгаа нь ч тэд Жужаны эрхшээлд байсныг батлах дам баримт хэмээн үзэж болно.

¹⁰ Rong Xinjiang. The Rouran Qaghanate and the Western Regions during the Second Half of the Fifth Century based on a Chinese Document Newly Found in Turfan. In *Great Journeys across the Pamir*. Brill's Inner Asian Library. Volume 37. 2018. p.65.

Карахожагийн оршуулгын газрын булшнаас юнканы 17 дугаар он (482 он)-д холбогдох бичгийн дурсгал олдсон нь элчийн бүртгэлийн мэдээллийг тодруулах боломж олгож байна. Энэ дурсгал нь Гаочан дахь элч нарт олгосон эд зүйлийн бүртгэл юм. Энэхүү бүртгэлд Роумэн тегин (若潛提懃 Roumin tiqin), Түди тегин Үгэн (秃地提懃無根 Tudi tiqin Wugen), Чулун Үгэн (處論無根 Chulun Wugen) хэмээх элчийн нэр гарч байгаа¹¹ бөгөөд эдгээрийг Жужаны элчийн нэр, цол хэмээн үзэж байна. Ялангуяа, *тегин* (tiqin) буюу *tegin* цолтой элч тэмдэглэгдсэн ихээхэн сонирхолтой юм. *Тегин* (tegin) цолыг эртний түрэгүүд анх хэрэглэсэн түрэг цол гэсэн ойлголт байдаг. Гэтэл жужанчууд *тегин* цолыг хэрэглэж байсныг сурвалжийн энэ мэдээ нотолж байгаагаараа ач холбогдолтой юм. “Сун улсын судар”-ын 95 дугаар бүлэг, “Өмнөд Ци улсын судар”-ын 57 дугаар бүлгийн мэдээгээр Тоба Вэй улсад “дигэн” цол байсан төдийгүй Эфталитууд *тегин* цол хэрэглэж байсан ажээ¹².

Мөн элчийн бүртгэлд гардагтай төсөөтэй Чулун Үгэн (Chulun Wugen) гэдэг элчийн нэр гарч байна. Чулоган (Chuluogan), Чулун (Chulun) гэдэг нь адил нэрийг ялгаатай тэмдэглэл хэмээн үзэж байна. Харин *үгэн* (無根 wugen) гэдэг нь Жужаны элчийн цол бололтой.

Элч нарт тараан өгсөн эд зүйлээс харахад, зарим элч нэлээд удаан хугацаагаар Гаочанд суудаг байсан ажээ. Жужанаас ирж байгаа элч нарын зарим нь татвар хураахаар ирж, Гаочанд удаан хугацаагаар суудаг байсан бололтой. Баруун бүсийн бусад улс руу явж байгаа Жужаны элч нар буцахдаа мөн Гаочанаар дайран өнгөрдөг байсан байна. Турфанаас Хами-ийг дайран, Тэнгэр уулын нэгэн салбарыг даван Жужаны нутаг руу явдаг торгоны замын энэ салаа нь Жужаны үед гол замын үүрэг гүйцэтгэж, элч төлөөлөгчид энэхүү замаар аялдаг байсныг элч нарын бүртгэл харуулж байна.

Түрэг Уйгурын үеэс сурвалжид энэхүү зам нь тодорхой тэмдэглэгдэж, “Хуйхуй зам” буюу “Уйгурын зам” хэмээн нэрлэгддэг билээ. Турфан, Хами-аас Тэнгэр уулын хойд салааг даван одоогийн Говь-Алтай аймгийн нутаг руу орж ирдэг “торгоны замын салаа” нь V зууны үед *жужанчууд* Таримын савын орнууд, Дундад Ази, умард Энэтхэг, өмнөд хятадын улсуудтай харилцах гол зам байсан нь сурвалжийн дээрх мэдээгээр нотлогдож байна. Энэ зам нь бүр Хүннүгийн үеэс Хүннү ба Турфан, Таримын бүс нутгийг холбодог торгоны гол зам байсаар ирсэн хэмээн үзэх нь зүйтэй санагдана. Ер нь баруун бүс нутгийг Хүннү, Сяньби, Жужантай холбодог энэхүү замаас гадна Турфан, Өрөмчөөс Алтайн нурууг Бодончийн хавцлаар даван Ховд аймгийн Булган сумаар орж ирдэг бас нэгэн зам эдүгээ ч байсаар байгаа билээ.

Түүнчлэн өмнөд хятадын Зин улс нь Тоба Вэй улстай дайсагнан байсан тул тэдний нутгаар дайралгүйгээр торгоны замтай холбогдох аюулгүй замыг эрэлхийлж байжээ. Өмнөд хятадууд Нанжинаас (Jiankang) гарч, Хөх мөрнөөр Чэндү хүрээд умард зүг эргэж, Түгүхүний нутаг Хөхнуур (Qinghai), Чэрчэн (cherchen)-өөр дайрч, Гаочан ордог замыг аюулгүй хэмээн үзэж, энэ замаар Жужантай харилцдаг байжээ.

Ийнхүү Турфан, Таримын сав нутгаас Тоба Вэй улсын нөлөөг шахан гаргаж, Жужанчууд дангаар ноёрхон, торгоны замын аюулгүй байдлыг хангах болсноор худалдаа, эдийн засаг, соёлын солилцоо эрчимтэй хөгжиж байсан ч 490-ээд онд болсон улс төрийн хэдэн үйл явдал бүс нутгийн хүчний харилцаанд өөрчлөлт оруулж, тогтворгүй байдлыг буй болгов.

¹¹ Rong Xinjiang. The Rouran Qaghanate and the Western Regions during the Second Half of the Fifth Century based on a Chinese Document Newly Found in Turfan. In *Creat Journeys across the Pamir*. Brill's Inner Asian Library. Volume 37. 2018. p.69.

¹² Edwin G. Pulleyblank. The Consonantal System of Old Chinese. Part II Appendix. The Hsiung-nu Language. *Asian Major*. Volume IX. 1962, p. 260.

4. Таримын бүс нутагт ноёрхохын төлөөх тэмцэл: Жужан, Өндөр тэрэгтэн, Эфталит, Түгүхүн (492 оноос VI зууны эхний хагас)

492 онд Жужаны хаантай зөрчилдөх болсон Өндөр тэрэгтэн (Гаочэ) нар зугтан энэ бүс нутагт нүүдэллэн ирж суурьшсан үйл явдал болон Эфталит улс хүчирхэгжин газар нутгаа зүүн тийш тэлэн, бүс нутгийн дотоод хэрэгт оролцох болсон нь хүчний харилцаанд өөрчлөлт гарч, тогтворгүй байдлыг буй болгов. Харин энэ үед Таримын сав нутаг дахь Тоба Вэй улсын нөлөө үлэмж буурсан билээ.

492 оны 8 дугаар сард Тоба Вэйгийн Гаозу хаан 12 жанжин 7 түмэн морин цэргээр Жужаныг довтох зарлиг буулган цэрэглэж, Түлүн хааныг дайлжээ. Түлүний харьяат аймгууд дайны хөлд бутарч сарнисныг далимдуулан фуфуло аймгийн Афужило, үеэл Цюнцигийн хамт буман хүнтэй аймгаа дагуулан Турфаны баруун хойно нүүж очжээ¹³. Ийнхүү *өндөр тэрэгтний* Афужило, Цюнци нар 100 мянгаад хүнтэй 12 аймаг өндөр тэрэгтнээ дагуулан Зүүн гарын нутагт нүүн ирсэн ажээ. “Сүй улсын судар”-т нэг түмэн цэрэгтэй дөрвөн аймагтай *өндөр тэрэгтнүүд* Алтай уулын баруун өмнө, хоёр түмэн цэрэгтэй найман аймагтай *өндөр тэрэгтнүүд* Хамигаас баруунш, Карашараас хойш орших Цагаан уулыг түшиж нутагладаг¹⁴ хэмээжээ. Ийнхүү *өндөр тэрэгтнүүд* хоёр хуваагдан умард этгээдэд Афужило, өмнөд талд нь Цюнци суурьшсан байна. Улмаар *өндөр тэрэгтнүүд* Гаочаныг эзлэн авч, Тоба Вэй улс руу элч илгээн, найрсаг харилцаа тогтоох санал тавьжээ. Гаочэ нар Тоба Вэйн дэмжлэгтэйгээр Жужаны эсрэг тэмцэх бодлого явуулж байв. Гэвч энэ үед *эфталитууд* Кунлин уулыг даван, зүүн тийш нөлөөгөө тэлэн Таримын сав нутагт нөлөөгөө бэхжүүлэх болов. “Вэй улсын судар”-ын 103 дугаар бүлэгт *өндөр тэрэгтэн* ба *жужаны* харилцааны талаар тодорхой өгүүлсэн ч он цагийг төдийлөн нарийн тэмдэглээгүй байдаг. Тарим сав газарт дорно зүгээс Жужан, өрнө талаас Эфталит гэсэн хоёр хүчирхэг улс хяналтаа тогтоохыг зорьж, *өндөр тэрэгтнүүд* тэдний дарамт шахалт, довтолгоонд өртөх болов. “Вэй улсын судар”-т тэмдэглэсэнээр, Эфталит улс довтолж *өндөр тэрэгтний* удирдагчдын нэг Цюнци нь *эфталитуудад* алагдаж, ард иргэд нь тэднийг дагах болсон бол түүний дүү Миэту нь Жужанд алагджээ. Жужан улс *өндөр тэрэгтнүүдтэй* олон удаа байлдаж, үндсэндээ *жужанчууд* ялж байсныг “Вэй улсын судар”-ын мэдээ нотолж байна. Тухайлбал, Цюнцийн хүү Миэту нь Бархөл нуурын ард Жужаны Богд хаантай байлдан ялагдан зугтаж байв. Богд хааныг Тобагийн цэргээс зугтаж явахад нь Миэту довтлон алж, гэзгийг нь огтолж Тоба Вэй улсад хүргүүлж байв. Гэвч Жужан улсын Чону хаан Миэтүг олзолж, морины сүүлнээс чирч алан, гавлын ясаар нь аяга хийсэн ажээ. Түүний өшөөг дүү Ифү авахыг оролдсон ч *жужанчуудад* дахин ялагдаж, улмаар төрсөн дүүдээ алагдсан байна. Үйл явдлын дарааллаас харахад энэ явдал 530-аад онд болсон ажээ. Ийнхүү Юэзюй нь ахыгаа хөнөөн *өндөр тэрэгтний* тэргүүн болж, Жужантай байлдсан ч ялагдан зугтжээ. Энэ байдлыг нь ашиглан Ифүгийн хүү Биши түүнийг алсан үйл явдал Тянь пиний үед (534-537 он) болсон хэмээн “Вэй улсын судар”-т тэмдэглэсэн байдаг. Биши Жужанд ялагдаж, Юэзюйн хүү Фюйбинь Тоба Вэй улсад зугтан очсоноор¹⁵ *өндөр*

¹³ Хандсүрэн Ц. *Жужаны хаант улс ба түүхийн зарим судалгаа*. УБ., 2005. т. 147, 144-145

¹⁴ 隋書 (Sui hu)。轉84. 北狄，鐵勒。第879頁

¹⁵ В.С.Таскин. *Материалы по истории древних кочевых народов группы Дунху*. Москва, 1984. с. 404-406; Б.Батсүрэн. *Өндөр тэрэгтэн ба эртний түрэгүүд (VI-IX зуун)*. УБ., 2009. т. 128-129; *Монголын эртний түүх: Түрэг Уйгур. Дөтгөөр боть*. УБ., 2017. т. 21-23.

тэрэгтнүүдийн тусгаар байдал үгүй болжээ. “Вэй улсын судар”-ын мэдээнээс үзэхэд, *өндөр тэрэгтнүүд* Жужан улсын цэрэгтэй олон удаа тулалдсан ч үндсэндээ *жуужанчууд* ялсаар байсан байна. Гэсэн хэдий ч *өндөр тэрэгтнүүдийн* эсэргүүцэл тэмцэл нь Жужан улсыг Тарим болон Зүүн гарын бүс нутагт ноёрхлоо бүрэн тогтоож, торгоны замыг хянаж нөлөөгөө өргөтгөх бодлогод ноцтой саад учруулсан билээ. Түүнчлэн Таримын сав нутагт Эфталитын хүч нөлөөг хязгаарлахад саад тотгор учруулж байв. Жужан улс Таримын сав нутагт Эфталиттай шууд тулгаран дайтахаас зайлсхийж, өмнөд зам дахь нөлөөг нь хүлээн зөвшөөрөх бодлого явуулахаас аргагүй байдалд хүрэхэд ч нөлөөлсөн гэж үзэж болно.

VI зууны эхээр *эфталитууд* баруун болон өмнөд Таримд нөлөөгөө тогтоон хянах болсон бол *жуужанчууд* хойд болон зүүн хойд Таримын нутгийг хянах болжээ. Жужан улс *эфталитуудын* баруун болон өмнөд Таримын сав нутаг дахь нөлөөг хүлээн зөвшөөрч, нөлөөний хүрээгээ тохирсноор *өндөр тэрэгтнүүдийг* хязгаарлах бодлого явуулсан байна. Ийнхүү Таримын сав нутгийн торгоны замын умард салааг *жуужанчууд* хянаж байсан бол, өмнөд зам *эфталитуудын* хяналтад орсон. Гэвч Таримын сав нутаг дахь *эфталитуудын* хүчирхэгжилт удаан үргэлжилсэнгүй, дотоод тэмцлийн улмаас Тарим дахь цэргийн хүч нөлөө нь үлэмж буурах болсон байна.

Харин *түгүхүньчууд* зүүн өмнөд Таримын сав нутагт нөлөөтэй байж, худалдааны замд хяналт тавьж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байв. Жужан болон *эфталитууд* улс төрийн дотоод нөхцөл байдлын улмаас Таримын бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж улам бүр буурч байхад, бүс нутаг дахь Түгүхүний нөлөө хүчтэй хэвээр байсан ажээ.

Таримын сав нутаг дахь нөлөөний хүрээгээ хувааснаар хүчний харилцаа тогтворжиж, нэгэн үе худалдааны замд тогтвортой байдал буй болов. Гэвч яваандаа *эфталитууд* Гоачэ нартай холбоо байгуулан Жужаныг Таримын сав нутгаас шахах замаар Таримын сав газрын орнуудыг өөрийн нөлөөндөө оруулж, торгоны замыг бүхэлд нь хянахыг зорих болсон. Ийнхүү VI зууны эхний хагаст Таримын сав нутагт тогтворгүй байдал үргэлжилж, зөрчил тэмцэл нэмэгдсэн байна.

Тарим сав газар нь олон улсын худалдааны замын нэг гол зангилаа нутгийн нутгийн хувьд худалдаа, эдийн засаг, соёлын солилцоо, олон улсын харилцаа, геополитекийн хувьд чухал ач холбогдолтой байсан тул Евразийн хүчирхэг гүрнүүд энэ бүс нутагт хяналтаа тогтоохын төлөө өрсөлдөн тэмцэлдсээр иржээ. Жужан улс нь V зууны туршид Турфан, Таримын сав нутагт эрхшээл нөлөөгөө тогтоон, торгоны замд хяналт тавьсаар байсан нь тэд хүчирхэг нөлөөтэй байсныг харуулж байна. VI зууны эхний хагаст *жуужанчууд* умард Таримын сав нутагт хүчирхэг нөлөөтэй байж, торгоны замыг өөрийн хяналтдаа байлгахын төлөө Өндөр тэрэгтэн, Түгүхүнь, Эфталитуудтай өрсөлдөн тэмцэлдсээр байсан билээ.

Дүгнэлт

Турфан, Таримын сав нутаг нь торгоны замын нэг гол зангилаа нутаг тул бүс нутгийн хүчирхэг улс гүрнүүд өөрийн эрхшээлдээ оруулан, торгоны замд хяналт тавихын төлөө өрсөлдөн тэмцэлдсээр иржээ. Сяньби гүрэн задарсны дараа Турфан, Таримын сав нутагт *жужанчууд* ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянах болсноор Евразийн хүчирхэг гүрэн болсон ажээ. Торгоны замд ноёрхлоо тогтоохын төлөөх Жужан улсын явуулсан бодлого, үйл ажиллагааг:

1. Турфан, Таримын сав нутгийн эрхшээлдээ оруулж, торгоны замыг хянах болсон үе (402-439 он)
2. Торгоны замд хяналтаа тогтоохын төлөөх Жужан, Тоба Вэй улсын өрсөлдөөний үе (439-460 он)
3. Турфан, Таримын бүс нутагт Жужан улс дангаар ноёрхож байсан үе (460-492 он)
4. Турфан, Таримын бүс нутаг дахь Жужан, Эфталит, Өндөр тэрэгтэн, Түгүхүний тэмцлийн үе (492 оноос VI зууны эхний хагас) хэмээн үечилж болох юм.

1997 онд Турфанаас олдсон “элчийн бүртгэл тэмдэглэл” нь Жужан улс нь Турфан, Таримын сав нутаг, умард Энэтхэг, өмнөд Хятадын улсуудтай өргөн дэлгэр харилцаатай байсныг нотлон харуулж байна. Турфан, Таримын сав нутгийг Монголын төв нутагтай холбодог Хятад сурвалжид “хуйхуй зам” (уйгурын зам) хэмээн тэмдэглэгдсэн умард торгоны замын нэг салаа нь Жужаны үед байжээ. Жужан улс нь V зуун болон VI зууны эхний хагасын туршид торгоны замыг хянаж, Евразийн олон улсын харилцааны нэг гол тоглогч байсан ажээ.

АВСТРАКТ

The Struggle for the Silk Road: Rouran and Northern Wei

After the downfall of the Xianbei state, the Rouran state rose to power in Eurasia by dominating Turfan and Tarim basin, taking control over the Silk Road routes. The time in which the Rouran state gain control over the Silk Road can be classified into different periods as follows:

1. Period in which the Rouran conquered the region of Turfan and Tarim basin and thus controlled the Silk Road (402-439 A.D)
2. Period in which the Rouran and the Toba (Northern) Wei struggled for the control over the Silk Road (439-460 A.D)
3. Period when the Rouran dominated in Turfan and Tarim basin (460- 492 A.D)
4. Period of wars between the Rouran, the Hephthalite and Tuguhun (492 – first half the 6th century)

“Envoy’s Account” found from Turfan in 1997 proves that Rouran maintained strong foreign relations with other states in the Turfan and Tarim Basin, Northern India, and Southern China. The Rouran controlled the Silk Road for 5th centuries and was a major power in Eurasia’s international relations.